



Илинкс Экспресс ХХК



www.ilinoxpress.mn



Баянгол дүүрэг:
2-р хороо Гранд
Плаза цогцолбор 1101

АЛСЫН ХАРАА

БИД МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН
ХӨГЖЛИЙГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ТОДОРХОЙЛНО.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үйлчлүүлэгчдийнхээ итгэл найдвараар жигүүрлэн, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн тээвэр логистикийн найдвартайцогц үйлчилгээг үзүүлж, чөлөөт зах зээлийн харилцаанд ёс зүйг эрхэмлэн, салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлнэ.
Ажлын хариуцлага, ёс зүйг дээдлэнэ.
Хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

“Илинкс Экспресс” ХХК-ийн түүхэн замнал

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааг ОХУ-аас БНХАУ-руу

Монголын нутгаар дамжин өнгөрөх мод, модон материал болон бордооны тээвэрлэлтээр эхлэв.

2005 он

Монгол улсын хилийн боомт Замын Үүд болон Сүхбаатар өртөөнд өөрийн албан ёсны салбарыг нээв.

Хятад улсын Бээжин хотод суурин төлөөлөгчийн газраа нээв.

2007 он

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг 50% -иар нэмэгдүүлэв.

Монголын Тээвэр Зуучлалын Үндэсний Холбооны Гишүүнээр элсэв.

2008 он

Автотээврийн үйлчилгээний хэлтсийг байгуулав. Аюултай болон химийн ачааг тээвэрлэж эхлэв.

2010 он

МУ-ын ЗГ болон МҮХАҮТ-аас шалгаруулсан ТОП 150 аж ахуйн нэгжид шалгарав.

Санхүүгийн Интерактив Diamond програмыг нэвтрүүлэв.

2012 он

Монголын Тээвэр Зуучлагчдын Нэгдсэн Холбоонд элсэж, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж эхлэв.

2014 он

Дамжин өнгөрөх тээврийн хэмжээ хамгийн их буюу 314,674 тонн-д хүрэв.

2016 он

Үйл ажиллагаагаа өргөжүүлэн БНХАУ-аас ОХУ-руу тээвэрлэлтийг эхлүүлэв.

2006 он

Тээвэр зуучлалын программыг нэвтрүүлж, тээврийн хөдөлгөөний мэдээллийг харилцагч, үйлчлүүлэгчиддээ 24 цагийн турш интернэтээр өгч эхлэв.

2007 он

Компани ажилтнуудынхаа ажиллах нөхцөлийг сайжруулан өөрийн эзэмшлийн шинэ оффист оров.

2009 он

FIATA (ОУ-ын Тээвэр зуучлалын холбоо)-нд гишүүнээр элсэн оров.

2011 он

МУ-ын ЗГ болон МҮХАҮТ-аас шалгаруулсан ТОП 150 аж ахуйн нэгжид шалгарав.

Монгол улсын ЗГ-аас хэрэгжүүлсэн утаагүй зуухны төслийн тээврийг БНТУ-аас амжилттай зохион байгуулав.

2013 он

БНХАУ-ын Эрээн хотод өөрийн суурин төлөөлөгчийн газраа нээв.

2015 он

УБТЗ-ын хамтын ажиллагааны ШИЛДЭГ “ТЭЭВЭР ЗУУЧ”-ийн байгууллагаар шалгарав.

2018 он

Ази тивийн аварга шалгаруулах ОУ-ын гимнастикийн тэмцээний техник хэрэгслийн тээврийг амжилттай зохион байгуулав.

2019 он

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Илинкс Экспресс ХХК нь 2005 оноос эхлэн олон улсын тээвэр зуучлал, тээвэр логистикийн үйлчилгээний чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Бид ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын харилцагч компаниудтай нягт хамтран ажилладаг төдийгүй харилцагч түншүүдийнхээ өргөн сүлжээгээр дамжуулан далай, төмөр зам, агаар, авто замын төрлөөр чингэлэг, задгай ачаа болон тусгай горим шаардсан ачаа тээврийг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ирсэн арвин туршлагатай баг хамт олон юм.

Танд 10 ба түүнээс дээш жил ажилласан дадлага туршлагатай тээврийн баг хамт олон үйлчилж байна. Бид цаг үеийн нөхцөл байдалд тохируулан тээвэр, логистикийн оновчтой шийдлүүдийг хэрэглэгчиддээ хүргэхийн зэрэгцээ орчин үеийн менежментийн давуу талуудыг ашиглан үйл ажиллагаагаа тогтмол сайжруулдаг нь бидний амжилтын үндэс юм.

Бид чөлөөт зах зээл дээрх бизнесийн ёс зүйг дээдэлж, тээвэр логистикийн салбар дахь хэрэглэгч, харилцагч болон оролцогч бүх талуудын эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, урт хугацааны найдвартай хамтын ажиллагааг эрхэмлэн Монгол улсын тээврийн салбарыг өргөжин хөгжихөд хувь нэмрээ оруулж байна.

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН БАГ



Тээврийн мэргэжилтэн
Э.Цэенрэгзэн
Skype: tsegii25
E-mail: tseeeye@ilinxexpress.mn
Утас: 96655252



Транзит тээврийн мэргэжилтэн
Я.Тэгшбаяр
Skype: tegsh.tegshee
E-mail: tegshee@ilinxexpress.mn
Утас: 96550050



Тээврийн мэргэжилтэн
Х.Баярмаа
Skype: bbe6853759ade585
E-mail: bayarmaa@ilinxexpress.mn
Утас: 96550080



Тээврийн мэргэжилтэн
С.Энхжаргал
Skype: jak_jargal
E-mail: jagaa@ilinxexpress.mn
Утас: 96651997



Тээврийн мэргэжилтэн
М.Энхсайхан
Skype: enkhsaikhan02
E-mail: m.enkhsaikhan@ilinxexpress.mn
Утас: 99057490



Эрээн хот дахь төлөөлөгч
Д.Галдансэвжид
Wechat ID: wxid_9j9c9g7wk93s12
E-mail: sevjid@ilinxexpress.mn
Утас: 99812403, 86-15847984411

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

ОХУ, БНХАУ, Транс Ази болон Европын өндөр хүчин чадал бүхий төмөр замын дэд бүтцийг ашиглаж, БНХАУ болон ОХУ-аар дамжуулан Европ, Дундад Азийн орнуудаас экспорт, импортын тээврийг төмөр замын тээврийн шийдлээр түргэн шуурхай, өрсөлдөхүйц үнэ тарифаар зохион байгуулж байна.

Таны ачаа төмөр замын бүсээс хол байсан ч бид авто тээвэртэй хослуулан тохирох холимог тээврийн нөхцлийг санал болгодог. Та ачааны онцлогтоо тохирсон вагоны бүх төрлөөс сонгон тээвэрлүүлэх боломжтой:

Хагас вагон

Битүү вагон

Платформ

Цистерн

Хөргүүртэй

Дулааны
тусгаарлалттай

Хоппер

ТРАНЗИТ ТЭЭВЭР

Илинк Экспресс ХХК нь Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн зах зээлд тэргүүлэх байр суурьтай компани болон өргөжиж, үйл ажиллагаагаа амжилттай зохион байгуулж ирсэн юм. Хэрэв танд болон таны бизнесийн түншид манай орноор дамжин өнгөрөх болон хилийн чанадад хийгдэх транзит тээврийн ачаа байгаа бол бид таны бизнесийн найдвартай түнш болж чадахаа илэрхийлэхэд таатай байна.

Бид дамжин өнгөрөх тээврийн мэдээллийг интернэтээр 24 цагийн турш мэдээлнэ.

Бичиг баримт бүрдүүлэлтийг хянаж, зөвлөгөө өгнө.

Хилийн өртөөн дээрх шилжүүлэн ачилтын явцыг хянаж ажиллана.

ОЛОН УЛСЫН АВТОЗАМЫН ТЭЭВЭР (ТИР)

ЕВРОП болон Турк улсын хотуудаас Улаанбаатар хот хүртэл TIR Carnet олон улсын гаалийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслээр

БНХАУ-н бүх хотоос Эрээн/Замын-Үүд, Ганц мод / Гашуун Сухайт, Улиастай /Бичигт, Сэхээ /Шивээ хүрэн зэрэг боомтуудаар дамжуулан хилийн болон гүний гаалийн бүрдүүлэлттэй ачаа тээвэр

ОХУ-н хотуудаас Монгол руу Хиагт/Алтанбулаг боомтоор дамжуулан хилийн болон гүний гаалийн бүрдүүлэлттэй ачаа тээвэр

Энгийн бүх
төрлийн
бараа
бүтээгдэхүүн

Хүнсний
ачаа

Температур
горим
шаардах

Овор ихтэй,
хүнд жинтэй
ачаа бараа



ТҮҮВЭР АЧААНЫ ТЭЭВЭР (LTL& LCL)

Бид дэлхийн аль ч улс орноос чингэлэг болон автомашинаар таны овор хэмжээ бага, ачааг түргэн шуурхай, найдвартай зохион байгуулж байна. Манай хамт олон таны ачааг харилцагч байгууллагуудынхаа сүлжээгээр дамжуулан ачаа бүрийн онцлогт тохирсон тээврийн шийдлээр товлосон хугацаанд нь эрсдэлгүй, найдвартай, аюулгүй, зорилтот үнээр тээвэрлэж байна.

Бид Европ болон Азийн улсуудаас түүвэр ачааны чингэлэг болон автозамын тээврийн үйлчилгээг ТАНД дараах чиглэлээр санал болгож байна.

Европ болон Дундад Азийн орнууд, ОХУ-аас харилцагч компаниудын агуулахаар дамжуулан энгийн, тусгай нөхцөл шаардсан, хурдан муудаж гэмтэх ачааг цуглуулж, олон улсын гаалийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл бүхий (TIR carnet) авто машин болон төмөр замаар түүвэр чингэлгийн тээвэрлэлтийг зохион байгуулна.

Түүвэр чингэлгийг Америк болон дэлхийн бусад орнуудаас БНСУ-ын Инчеон боомтоор дамжуулан агаар, далай, төмөр замын хосолсон тээврээр зохион байгуулна.

ШИНЭ БОЛОН ХУУЧИН АВТОМАШИНЫ ТЭЭВЭР

Бид дараах тээвэрлэлтийн төрлүүдээр АНУ, Канад, Европ, Дундад болон Зүүн Өмнөд Азийн орнуудаас шинэ болон хуучин автомашины тээврийг зохион байгуулж байна:

Далайгаар
RORO

Чингэлэгээр

Вагоноор
(тусгай
зориулалтын)

Автомашинаар
(ТИР)

ТӨСЛИЙН БОЛОН ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН ТЭЭВЭР

Бид төсөл хэрэгжүүлэгч төр болон хувийн хэвшлийн бүх талуудтай хамтран ажиллаж, төслийн тээвэр логистикийн үйлчилгээг чанартай, найдвартай үзүүлж байна.

Бид таны бизнес, төсөл хөтөлбөрт тохирсон тээвэр логистикийн үйлчилгээг онцгой нөхцөлд асуудлыг уян хатнаар шийдвэрлэх мэргэжилтнүүдийн нарийвчилсан төлөвлөлтөөр дамжуулан үйлчлүүлэгчийн гэрээнд заасан хугацаанд үзүүлж байна.



АГААРЫН ТЭЭВЭР

Бид агаарын тээвэрлэгчийн өргөн сүлжээгээр дамжуулан дэлхийн аль ч улс дахь илгээгчийн хаалганаас, хүлээн авагчийн хаалганд таны ачаа барааг найдвартай хүргэнэ. Агаарын тээвэр нь түргэн муудах эсвэл нарийн мэргэжлийн, эмзэг тусгай нөхцөл шаардсан тоног төхөөрөмж болон өндөр үнэтэй ачааг хамгийн богино хугацаанд хүргэх шийдэл юм.

Та агаарын тээврийн үнийн санал авахдаа ачааны ерөнхий мэдээлэл, тээвэрлэлтэд бэлтгэсэн сав баглаа боодол бүхий ачааны гаднах гурвалсан хэмжээс, ачааны бохир жингийн хэмжээ, ачаа авах газрын хаягийг өгөх шаардлагатай.

Агаар болон
далайн холимог
тээвэр

Агаар болон
автын холимог
тээвэр

АЮУЛТАЙ БОЛОН ХИМИЙН АЧАА

Аюултай ачааг энгийн зорчигч тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглосон байдгаас гадна зарим улс төмөр замаар тээвэрлэхийг, эсвэл бүр газар нутгаараа дамжуулан тээвэрлэхийг хориглодог.

Бид уул уурхайн зориулалтын тэсэлгээний хэрэгсэл, химийн ачаа тусгай нөхцлөөр тээвэрлэх шаардлагатай аюултай ачааны тээвэрлэлтийг тухайн бараа бүтээгдэхүүний онцлог, шинж чанар, тээвэрлэлтийн нөхцөл, технологи, дамжин өнгөрүүлэх улс болон Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд тавигдах шаардлага, дүрэм журам, стандартын хэв хэмжээнд нийцүүлэн тээвэрлэлтийг мэргэжлийн түвшинд зохион байгуулж байна..

Мөн бид дээрх нэр төрлийн ачааг тусгай зөвшөөрөл бүхий өөрийн автомашинаар хаалганаас хаалганд хүргэх үйлчилгээг хот дотор болон орон нутагт таны хүссэн газарт хүргэж үйлчилнэ. Тиймээс та ачаа тээвэрлүүлэх байгууллагаа сонгохдоо аюултай ачаа тээвэрлэж байсан туршлагыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай юм.

ГААЛИЙН ЗУУЧЛАЛ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Импорт болон экспортын гаалийн бүрдүүлэлтийг Улаанбаатар дахь терминалууд болон өөрийн компанийн салбар төлөөлөгчийн газруудаар дамжуулан БНХАУ-ын Эрээн болон Замын-Үүд, Сүхбаатар зэрэг өртөөдүүдэд гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээг үзүүлж байна.

Манай хамт олон Монгол улсын хил болон УБ хот дахь гааль дээр гаалийн баримт бичгийн бүрдүүлэлт, мэдүүлгийн дараах үйлчилгээг үзүүлж байна.



ХААЛГАНААС ХААЛГАНД ҮЙЛЧИЛГЭЭ

Үйлчлүүлэгч таны хүсэлтийн дагуу задгай болон чингэлэгтэй ачааг өөрийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг ашиглан хот дотор болон орон нутагт хүссэн газарт тань хүргэж байна. Мөн таны экспорт, импортын бүх төрлийн ачааг хүссэн газраас татаж авах/хүргэх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд энгийн, задгай ачаа бараанаас эхлээд хэтрүү овортой техник, тоног төхөөрөмж, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардсан аюултай ачаа, бүх төрлийн чингэлэгт тээврийн үйл ажиллагаа багтана.



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГА



Улаанбаатар төмөр зам



Олон улсын тээвэр
зуучлагчдын холбоо



Монголын тээвэр зуучлагчдын
нэгдсэн холбоо



Худалдаа аж үйлдвэрлэлийн
тэнхим



Улсын мэргэжлийн
хяналтын газар



Автотээврийн үндэсний
төв



Гаалийн ерөнхий
газар



БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ



+976 - 70121115, +976 - 70121113



+976 - 70121116



info@ilinxexpress.mn , mail@ilinxexpress.mn



www.ilinxexpress.mn



Илинкс Экспресс ХХК
Төв Оффис, Баянгол дүүрэг, 2-р хороо, Гранд Плаза цогцолбор 1101
Улаанбаатар - 14250, Монгол Улс Шуудангийн хайрцаг - 94, Салбар - 44



Даваа-Баасан: 08:30am-17:30pm
Бямба-Ням: Амарна

